

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/136/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Аудитор: Б.Должинжав Утас: 70432545 цахим хаяг: Doljinjav.b@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.БАТЧУЛУУН ТАНАА

2021.02.25 № 2/145
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 -д заасны Нийгмийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, нийгмийн даатгалын тухай багц хуулийг хэрэгжүүлэх, аж ахуй нэгж байгууллага иргэдийг нийгмийн даатгалд даатгах, нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, тэтгэвэр, тэтгэмж төлбөрийг цаг тухайд нь олгох зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

001000175

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЙДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,376,710.04	13,878,569.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,431,450.04	1,631,362.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,431,450.04	1,631,362.50
3121	Төгрөг	6,431,450.04	1,631,362.50
31211	Төрийн сангийн харилцах	6,429,922.00	1,629,922.00
31213	Арилжааны банк дахь харилцах	1,528.04	1,440.50
33	АВЛАГА	709,672.00	7,813,921.00
335	Бусад авлага	709,672.00	7,813,921.00
3351	Байгууллагаас авах авлага	709,672.00	7,813,921.00
34	УРЬДЧИЛГАА	800,000.00	-
3471	Урьдчилгаа тооцоо	800,000.00	-
34713	Цалингийн урьдчилгаа	800,000.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	7,435,588.00	4,433,286.00
354	Хангамжийн материал	7,435,588.00	4,433,286.00
35410	Бичиг хэргийн материал	238,200.00	
35420	Аж ахуйн материал	5,528,140.00	3,440,550.00
35470	Бусад хангамжийн материал	1,669,248.00	992,736.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,325,333,205.96	1,297,343,296.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,325,333,205.96	1,297,343,296.68
392	Биет хөрөнгө	1,307,951,205.96	1,279,961,296.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,311,956,731.58	1,311,956,731.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	(73,034,722.77)	(99,799,257.99)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	51,300,000.00	51,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(47,218,504.11)	(51,300,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	118,356,460.00	80,915,641.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(90,388,485.81)	(48,745,977.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,895,012.00	63,285,012.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,915,284.93)	(27,650,852.80)
393	Биет бус хөрөнгө	17,382,000.00	17,382,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,382,000.00	17,382,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,340,709,916.00	1,311,221,866.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,340,709,916.00	1,311,221,866.18
51	Засгийн газрын хувь оролцоо	1,340,709,916.00	1,311,221,866.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	475,088,887.06	475,088,887.06
51101	Өмч: - төрийн	475,088,887.06	475,088,887.06
512	Хуримтлагдсан үр дүн	854,501,932.69	825,013,882.87
51210	Өмнөх үеийн үр дүн	914,448,036.88	854,695,436.80
51220	Тайлант үеийн үр дүн	(59,946,104.19)	(29,681,553.93)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,119,096.25	11,119,096.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,340,709,916.00	1,311,221,866.18

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	660,783,051.25	829,676,478.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,485,471.25	1,572,303.15
120	Нийтлэг татварын бус орлого	10,485,471.25	1,572,303.15
120002	Хүүгийн орлого	7,249.25	4,803.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,333,300.00	1,567,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,333,300.00	1,567,500.00
120009	Бусад орлого	7,144,922.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	650,297,580.00	828,104,175.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,406,880.00	8,857,090.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,406,880.00	3,857,090.00
1330	Төсвийн захирагчдаас	8,041,100.00	38,470,285.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,041,100.00	38,470,285.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	635,849,600.00	780,776,800.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	635,849,600.00	780,776,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	720,729,155.44	859,358,032.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	720,729,155.44	859,358,032.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	706,227,104.23	793,669,677.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	436,202,325.00	518,605,348.33
210101	Үндсэн цалин	361,003,036.00	381,494,441.77
210102	Нэмэгдэл	62,606,489.00	91,445,181.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,592,800.00	22,932,000.00
210104	Урамшуулал		22,733,725.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,286,634.00	64,949,776.00
210201	Тэтгэврийн даатгал	38,347,672.80	43,477,380.06
210202	Тэтгэмжийн даатгал	4,737,604.63	5,371,346.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,786,646.51	4,293,180.19
210204	Ажилгүйдлийн даатгал	945,229.46	1,071,671.30
210205	Эрүүл мэндийн даатгал	9,469,480.60	10,736,197.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,639,182.00	69,402,054.00
210301	Гэрэл, цахилгаан	4,304,549.00	3,608,154.00
210302	Түлш, халаалт	52,245,833.00	60,541,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,088,800.00	5,252,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,056,170.00	37,003,029.00
210401	Бичиг хэрэг	7,819,100.00	7,602,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,390,200.00	12,329,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,675,700.00	3,225,893.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	227,200.00	1,347,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,943,970.00	12,497,736.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,265,800.00	4,475,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,336,600.00	2,868,450.00
210604	Урсгал засвар	2,929,200.00	1,607,300.00
2107	Томилолт, зочны зардал	10,296,480.00	2,269,500.00
210702	Дотоод албан томилолт	10,296,480.00	2,269,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,071,272.44	33,737,532.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,940,100.00	22,744,416.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	693,000.00	1,386,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	683,100.00	983,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63,100.00	38,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	0.00	250,000.00
210807	Газрын төлбөр	103,870.00	50,440.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,000.00	183,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,489,102.44	8,101,776.00
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	0.00	0.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	0.00	0.00
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	0.00	0.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	0.00	0.00
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,409,240.79	63,226,688.39
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,970,000.00	1,856,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,439,240.79	61,370,488.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,502,051.21	65,688,354.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,162,902.00	35,362,961.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,162,902.00	11,599,561.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	23,763,400.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,339,149.21	30,325,393.36
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,339,149.21	30,325,393.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(59,946,104.19)	(29,681,553.93)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(59,946,104.19)	(29,681,553.93)

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	653,454,151.25	793,148,293.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,197,671.25	3,514,403.15
120	Нийтлэг татварын бус орлого	11,197,671.25	3,514,403.15
120002	Хүүгийн орлого	7,249.25	4,803.15
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,045,500.00	3,509,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	712,200.00	1,942,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,333,300.00	1,567,500.00
120009	Бусад орлого	7,144,922.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	642,256,480.00	789,633,890.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,406,880.00	8,857,090.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,406,880.00	3,857,090.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	635,849,600.00	780,776,800.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	635,849,600.00	780,776,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	647,022,701.21	792,948,380.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	647,022,701.21	792,948,380.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	632,520,650.00	727,260,026.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,454,300.00	517,353,373.33
210101	Үндсэн цалин	354,642,500.00	383,254,943.92
210102	Нэмэгдэл	70,219,000.00	90,816,931.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,592,800.00	21,158,000.00
210104	Урамшуулал	-	22,123,498.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,931,700.00	72,506,000.00
210201	Тэтгэврийн даатгал	37,440,679.98	48,535,516.40

210202	Тэтгэмжийн даатгал	4,625,551.59	5,996,246.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,697,085.37	4,792,646.60
210204	Ажилгүйдлийн даатгал	922,873.05	1,196,349.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,245,510.01	11,985,241.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,313,700.00	69,402,054.00
210301	Гэрэл, цахилгаан	4,760,600.00	3,608,154.00
210302	Түлш, халаалт	60,464,300.00	60,541,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,088,800.00	5,252,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,994,300.00	31,819,293.00
210401	Бичиг хэрэг	7,767,600.00	7,363,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,390,200.00	12,329,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,675,700.00	3,225,893.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	227,200.00	1,347,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,933,600.00	7,552,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,265,800.00	4,475,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,336,600.00	2,868,450.00
210604	Урсгал засвар	2,929,200.00	1,607,300.00
2107	Томилолт, зочны зардал	10,296,480.00	2,269,500.00
210702	Дотоод албан томилолт	10,296,480.00	2,269,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,294,370.00	27,577,856.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,940,100.00	22,744,416.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	693,000.00	1,386,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	683,100.00	983,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63,100.00	38,000.00
	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	250,000.00
210807	Газрын төлбөр	103,870.00	50,440.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,000.00	183,700.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	712,200.00	1,942,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,970,000.00	1,856,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,970,000.00	1,856,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,502,051.21	65,688,354.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,162,902.00	35,362,961.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	11,162,902.00	11,599,561.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	23,763,400.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,339,149.21	30,325,393.36
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,339,149.21	30,325,393.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	6,431,450.04	199,912.46
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	5,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	5,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		5,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(5,000,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	6,431,450.04	(4,800,087.54)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,431,450.04

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,431,450.04	1,631,362.50
----	---	--------------	--------------

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	475,088,887.06	11,119,096.25	914,448,036.88	1,400,656,020.19
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	475,088,887.06	11,119,096.25	914,448,036.88	1,400,656,020.19
Тайлант үеийн үр дүн			-59,946,104.19	-59,946,104.19
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	475,088,887.06	11,119,096.25	854,501,932.69	1,340,709,916.00
2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	475,088,887.06	11,119,096.25	794,555,828.50	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			193,504.11	193,504.11
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	475,088,887.06	11,119,096.25	854,695,436.80	1,340,903,420.11
Тайлант үеийн үр дүн			-29,681,553.93	-29,681,553.93
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	475,088,887.06	11,119,096.25	825,013,882.87	1,311,221,866.18

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ЭЗА	Зардлын ангилал	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	780,776,800.00	753,596,188.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	780,776,800.00	753,596,188.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	750,325,900.00	723,186,317.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	539,921,900.00	517,353,373.33
210101	Үндсэн цалин	415,875,700.00	383,254,943.92
210102	Нэмэгдэл	91,087,800.00	90,816,931.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,118,400.00	21,158,000.00
210104	Урамшуулал	6,840,000.00	22,123,498.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,506,000.00	72,506,000.00
210201	Тэтгэврийн даатгал	50,966,500.00	48,535,516.40
210202	Тэтгэмжийн даатгал	5,384,900.00	5,996,246.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,307,900.00	4,792,646.60
210204	Ажилгүйдлийн даатгал	1,077,100.00	1,196,349.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,769,600.00	11,985,241.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,513,900.00	69,402,054.00
210301	Гэрэл, цахилгаан	4,720,000.00	3,608,154.00
210302	Түлш, халаалт	60,541,600.00	60,541,600.00
210303	Цэвэр, бохир ус	5,252,300.00	5,252,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,116,700.00	28,115,293.00
210401	Бичиг хэрэг	7,363,800.00	7,363,800.00
210402	Тээвэр, шатахуун	12,329,500.00	12,329,500.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,227,300.00	3,225,893.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,347,900.00	1,347,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,848,200.00	3,848,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,475,900.00	4,475,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,868,600.00	2,868,450.00
210604	Урсгал засвар	1,607,300.00	1,607,300.00
2107	Томилолт, зочны зардал	2,278,800.00	2,269,500.00
210702	Дотоод албан томилолт	2,278,800.00	2,269,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,656,500.00	25,635,756.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,555,100.00	22,744,416.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,386,000.00	1,386,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	983,200.00	983,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	248,000.00	38,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00
210807	Газрын төлбөр	50,500.00	50,440.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	183,700.00	183,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,856,200.00	3,428,590.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,572,390.69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,856,200.00	1,856,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,450,900.00	30,409,871.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,450,900.00	30,409,871.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,687,500.00	6,646,471.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,763,400.00	23,763,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	780,776,800.00	753,596,100.48
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	780,776,800.00	752,023,797.33
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	780,776,800.00	752,023,797.33
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	1572303.15
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,572,303.15
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,528.04
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,440.50
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	46	45
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	37	36
620003	Үйлчлэх ажилтан	8	8

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8857090.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3857090.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3704000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3704000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3704000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	153090.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	153090.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	153090.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5000000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5000000.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5000000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8857090.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8857090.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5000000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3857090.00

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг байгууллагын дарга Н.Батчулуун танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилт, төлбөртэй үйлчилгээний орлогын бүрдүүлэлт, бүртгэл журнал, дотоод хяналт, бараа материалын бүртгэл, ангиллын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 16-наас 2021 оны 02 дугаар сарын 18-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Должинжав хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Нийгмийн даатгалын хэлтэс нь “Даатгуулагчийн итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэсэн эрхэм зорилгоо тодорхойлон ажилласан байна.

Нийгмийн даатгалын хэлтэс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай багц хуулийг хэрэгжүүлэх, аж ахуй нэгж байгууллага иргэдийг нийгмийн даатгалд даатгах,
- нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах,
- нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулах,

- тэтгэвэр тогтоох, нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах, даатгуулагч иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг найдвартай хөнгөн шуурхай хүргэх, даатгуулагчдын нийгмийн баталгааг хангах,
- нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний стандарт, чанар хүртээмж, үйлчилгээний соёл, сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам,
- Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн байгууллага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн ч санхүү, нягтлан бодох бүртгэлийн шинэчлэгдсэн эрхзүйн актын хүрээнд баяжуулалт хийж батлуулаагүй байна.

Цар тахлын улмаас Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой дотоод болон бусад хяналт, шалгалт 2020 онд хийгдээгүй байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 720729.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7207.3 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 859358.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8593.5 мянган төгрөгөөр тооцсон болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29488.1 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар буурчээ. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт нь үндсэн хөрөнгийн дансанд гарсан байна. *Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	15,376.7	13,878.6	-1,498.1
31	Мөнгөн хөрөнгө	6,431.5	1,631.4	-4,800.1
33	Авлага	709.7	7,813.9	7,104.3
34	Урьдчилгаа	800.0	-	-800.0
35	Бараа материал	7,435.6	4,433.3	-3,002.3
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,325,333.2	1,297,343.3	-27,989.9
39	Үндсэн хөрөнгө	1,325,333.2	1,297,343.3	-27,989.9
3	Нийт хөрөнгийн дүн	1,340,709.9	1,311,221.9	-29,488.1
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,340,709.9	1,311,221.9	-29,488.1
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,340,709.9	1,311,221.9	-29,488.1

Мөнгөн хөрөнгө дансны 1631.4 мянган төгрөгийн 1629.9 мянган төгрөг нь ахмадын сангийн төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл, 1.4 мянган төгрөг нь арилжааны банкны лавлагааны хураамжийн орлогын дансны үлдэгдэл байна.

Авлага дансны үлдэгдэл дэх 7813.9 мянган төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлтийн тооцоо байна.

Тайлант онд 30114.0 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн зардлаас худалдан авч, 10283.2 мянган төгрөгийн бараа материалыг дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авч, 43399.5 мянган төгрөгийн материалыг үйл ажиллагаанд зарцуулжээ.

Хүснэгт-2 /мянган төгрөг/

Үзүүлэлт	Дүн
Оны эхний үлдэгдэл	7,435.6
Нэмэгдсэн	40,397.2
Худалдан авсан	30,114.0
Шилжүүлэн авсан	10,283.2
Хасагдсан	43,399.5
Худалдсан, зарцуулсан	43,399.5
Эцсийн үлдэгдэл	4,433.3

Үндсэн хөрөнгө данс оны эхэнд 1560890.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 33187.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 69237.9 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, оны эцэст 1524839.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болжээ.

Хүснэгт-3 мянган төгрөг

Үзүүлэлт	Дүн
Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	1,560,890.2
Нэмэгдсэн	33,187.1
Худалдан авсан	5,000.0
Шилжүүлэн авсан	28,187.1
Хасагдсан	69,237.9

Акталсан	69,237.9
Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,524,839.4
Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	235,557.0
Элэгдлийн зардал тайлант хугацааны	61,370.5
Дансны хасалт	(69,431.4)
Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл	227,496.1
Үлдэгдэл өртөг	1,297,343.3

Нийгмийн даатгалын ерөнхий газраас 28187.1 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 5000.0 мянган төгрөгийн ТЭХ үнэ төлбөргүй хүлээн авч, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын хөрөнгө актлах, шилжүүлэх тухай 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/74, 2020 оны 12 дугаар сарын 31-ны А/161 шийдвэрээр нийт 69237.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ТЭХ-ыг актлаж данс бүртгэлээс хассан байна.

Биет бус хөрөнгөд нийт 17382.0 мянган төгрөгийн үнэлгээтэй 2 байршилд газар бүртгэлтэй байна.

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл оны эхэнд 475088.8 мянган төгрөг байсан ба тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 168893.4 мянган төгрөгөөр буюу 25.5 хувиар өсчээ.

Хүснэгт-4 /мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	660,783.1	829,676.5	168,893.4
120002	Хүүгийн орлого	7.2	4.8	-2.4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,333.3	1,567.5	-1,765.8
120009	Бусад орлого	7,144.9	-	-7,144.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,406.9	8,857.1	2,450.2
1330	Төсвийн захирагчдаас	8,041.1	38,470.3	30,429.2
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	635,849.6	780,776.8	144,927.2

Өмнөх оны үзүүлэлтээс орлого материаллаг хэмжээгээр нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд 38470.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, түүнчлэн нийгмийн даатгалын сангийн санхүүжилт 144927.2 төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Нийт зардал өмнөх оноос 138628.9 мянган төгрөгөөр буюу 19.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад материаллаг өөрчлөлтөд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 90066.1 мянга, урсгал шилжүүлгийн зардал 51186.3 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөө үзүүлжээ.

Хүснэгт-5 /мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	720,729.2	859,358.0	138,628.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	436,202.3	518,605.3	82,403.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,286.6	64,949.8	7,663.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,639.2	69,402.1	9,762.9
2104	Хангамж, бараа материалын зардал	30,056.2	37,003.0	6,946.9

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,265.8	4,475.8	(790.1)
2107	Томилолт, зочны зардал	10,296.5	2,269.5	(8,027.0)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,071.3	33,737.5	(2,333.7)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,409.2	63,226.7	(8,182.6)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,502.1	65,688.4	51,186.3

Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өссөн шалтгаан нь Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс, урсгал шилжүүлгийн зардал нэмэгдсэн шалтгаан нь тайлант оны орлого, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 28753.0 мянган төгрөг буцаан төвлөрүүлснээс, мөн нэг албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж 23763.4 мянган төгрөг олгосон нь материаллаг нөлөө үзүүлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 836301.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 836301.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 55524.2 мянган төгрөгөөр бууруулж тайлант онд 780776.8 мянган төгрөгөөр батлагдсан нь өмнөх оныхоос 144927.2 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд: Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 119041.9 мянга, урсгал шилжүүлгийн зардал 22450.9 мянган төгрөгөөр өссөн гол нөлөө үзүүлжээ.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 780,776.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 780,776.8 мянган төгрөгийг нийгмийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр санхүүжилт бүрэн авч, даатгалын лавлагааны хураамжийн 1572.3 мянган төгрөгийн орлого, нийт 782349.1 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 753596.1 мянган төгрөгийг зарцуулж 28753.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 753596.1 мянган төгрөг буюу 96.5 хувьтай байна Энэ нь тайлант жилийн хугацаанд 1 орон тоо дутуу ажилласнаас хамаарч цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, Ковид-19 вирусны нөхцөл байдлаас хамаарч сумдаар ажиллах зарим ажил хэрэгжээгүйтэй холбоотой зөвлөл, хороо, комиссын гишүүдийн цалин урамшууллын зардлыг тус тус хэмнэсэнээс шалтгаалжээ.

Хөтөлбөр	Зориулалт	Арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
71901	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	722,770.8	698,869.5	(23,901.3)
71901	80103	Гэрээгээр ажил гүйцэтгүүлэх	6,142.5	6,043.4	(99.1)
71901	80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	3,000.0	2,976.8	(23.2)
71901	80213	Өмгөөлөл, хуулийн зөвлөх	990.0	990.0	-
71901	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	17,422.6	12,734.2	(4,688.4)
71901	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	23,763.4	23,763.4	-
71901	80813	Хуульд заасан үндэслэлээр алба	2,187.5	2,185.0	(2.5)
71901	80820	Бусад тусламж, дэмжлэг	4,500.0	4,461.5	(38.5)

	1572.3	1572.3
ДҮН	780,776.8	753,596.2 (27,180.6)

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Нийгмийн даатгалын ерөнхий газраас 3857.1 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт, аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 5000.0 мянган төгрөгийн хөрөнгийн санхүүжилт, нийт 8857.1 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, холбогдох зориулалтын арга хэмжээнд 8857.1 мянган төгрөгийг зарцуулжээ

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой байдал хангалтгүй байна. Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, 6 мэдээллийг хугацаа хоцроож, 151 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон акт, албан шаардлага, өгөгдсөн зөвлөмж байхгүй болно.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23313.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21740.8 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчлийг залруулж, 1572.3 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материалын дансаар дамжуулаагүй бүртгэсэн 7841.3 төгрөгийн зарцуулалтыг няравын тайлан тусган залруулж бүртгэсэн
2. Зарим бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ, шийдвэр тодорхой бус, гэрээний хэрэгжилт тооцоогүй, ажлын тайлан, илтгэх хуудас, холбогдох баримт дутуу, бараа материалын зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

Нийт 21740.8 мянган төгрөгийн бүртгэлийн болон анхан шатны баримтын бүрдлийн дутуу, зөрчилд залруулга хийв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил байхгүй болно.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1572.3 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Балансын дараах үйл явдал болон дарагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Лавлагааны хураамжийн орлогыг төсөвт төлөвлөөгүй, төрийн сангийн харилцах дансаар дамжуулахгүйгээр дээд шатны байгууллагад төвлөрүүлсэн байна.

1.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль зөрчигдөх, төрийн сангийн нэгдсэн систем дэх төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Бүх шатны төсөв боловсруулах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналтыг төсвийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ" гэсэн заалттай нийцүүлэн төсвийн орлогыг төлөвлөж, төрийн сангийн харилцах дансаар дамжуулан хэрэгжүүлэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн зарим зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн.

2.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль зөрчигдөх, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

2.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу "Төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй" гэсэн заалттай нийцүүлэн төсвийг бодитой төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж, үнэн зөв тайлагнах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Нийгмийн даатгалын хэлтсийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ХОА-2021/136/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Нийгмийн даатгалын хэлтэс		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Лавлагааны хураамжийн орлогыг төсөвт төлөвлөөгүй, төрийн сангийн харилцах дансаар дамжуулахгүйгээр дээд шатны байгууллагад төвлөрүүлсэн байна.	1572.3	Зөвлөмж	Дарга, Ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч	Н.Батчулуун Д.Энхжаргал С.Гантулга
2	Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн зарим зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн.	-	Зөвлөмж	Дарга, Ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч	Н.Батчулуун Д.Энхжаргал С.Гантулга
3	Бараа материалын дансаар дамжуулаагүй бүртгэсэн 7841.3 төгрөгийн зарцуулалтыг няравын тайлан тусган залруулж бүртгэсэн	7841.3	Залруулсан	Дарга, Ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч	Н.Батчулуун Д.Энхжаргал С.Гантулга
4	Зарим бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ, шийдвэр тодорхой бус, гэрээний хэрэгжилт тооцоогүй, ажлын тайлан, илтгэх хуудас, холбогдох баримт дутуу, бараа материалын зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.	13899.5	Залруулсан	Дарга, Ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч	Н.Батчулуун Д.Энхжаргал С.Гантулга
ДҮН		23313.1			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР